



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар A/222

Улаанбаатар хот

Г Түр журам батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.3, 8.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Коронавируст халдварт (COVID-19)-ын үед жирэмсэн эмэгтэй, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусlamж, үйлчилгээг зохицуулах түр журмыг хавсралтаар баталсугай.
- Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Энхтөр/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, захирал наарт үүрэг болгосугай.
- Уг тушаалын хэрэгжилтэд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн газар /Я.Буянжаргал/, Эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөл (Б.Цэдмаа), Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл (Б.Баясгалантай), тархварзүйн болон эмнэлзүйн зөвлөх багт тус тус даалгасугай.
- Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/-д даалгасугай.



2020-A-tushaal

141200766

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04
дүгээр сарын 06-ны өдрийн
тушаалын хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ҮЕД ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙ,
ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЗОХИЦУУЛАЛТЫН ТҮР ЖУРАМ

Нэг. Үндэслэл

Дэлхийн улс орнуудад коронавирусийн халдварт (КОВИД-19) дэгдэлт хэлбэрээр гарч, олон хүнийг хамран өвчлүүлж, эндэгдэлд хүргэж байна.

Жирэмсэн эмэгтэй, хүүхэд COVID-19-ийн халдварт өртөмтгийн байгаа тухай шинжлэх ухааны үндэслэлтэй баримт одоогоор байхгүй байгаа боловч жирэмсэн эхийн билемахбодид гарч буй өөрчлөлтийн улмаас зарим жирэмсэн эмэгтэй, хүүхэд вирусийн гаралтай амьсгалын замын халдварт өртөмтгийн болдог. Иймд, сөрөг үр дагавар бүхий эрсдэл ихтэй, амьсгалын замын өвчтэй жирэмсэн эмэгтэй, хүүхдийг нэн түрүүнд эмчлэх, тэдэнд өвөрмөц тусlamж, үйлчилгээ үзүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Зорилго

COVID-19 халдвартын үед тусгаарлах байранд, гэрээр тусгаарлагдан ажиглалтад байгаа жирэмсэн эмэгтэй, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусlamж, үйлчилгээг зохицуулах

Гурав. Жирэмсэн эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ

3.1. Тусгаарлан ажиглах байранд ажиллаж байгаа эмч тусгаарлалтад байх хугацаанд жирэмсэн эмэгтэй, хүүхдийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана.

3.2. Тусгаарлан ажиглах байранд байгаа жирэмсэн эмэгтэй, хүүхдэд эрүүл мэндийн шаардлагатай тусlamж, үйлчилгээг орон нутагт Нэгдсэн эмнэлэгт, нийслэлд Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд мэдэгдэж, мэргэжлийн эмчийн зөвлөгөөг авна.

3.3. Дуудлага авсан байгууллага мэргэжлийн эмч томилж, тодорхой хугацааны давтамжтай үзлэг хийх хугацаа, цагийн товлолыг батлуулж, тусгаарлан ажиглах байрны эмч, удирдлагад хүргүүлж ажиллана.

3.4. Томилогдсон эмч тухайн тусгаарлах байрны эмчтэй холбогдох, жирэмсэн эмэгтэй, хүүхдийн биеийн байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч, цахимаар болон утсаар зөвлөгөө өгөх, эсвэл очиж эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх талаар шийдвэр гаргана.

3.5. Жирэмсэн эмэгтэй, хүүхэд гэрийн тусгаарлалтад байгаа бол өрх, сумын эмч эмэгтэйн биеийн байдлыг жирэмсэн эмэгтэй, хүүхдийг Улсын Онцгой Комиссын орлогч дарга, Онцгой Байдлын Ерөнхий газрын даргын "Гэрийн тусгаарлалт, ажиглалтад байгаа иргэдийн хяналтыг зохицуулах түр журам"-ын 4 дэх заалт болон

Эрүүл мэндийн сайдын “Коронавируст халдварт (COVID-19)-ын үед иргэдийг гэрт нь үргэлжлүүлэн тусгаарлах түр журам”-ын дагуу өдөр бүр утсаар, эсвэл нийгмийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл авч хянана.

3.6. Тусгаарлах байранд болон гэрийн тусгаарлалтад байгаа хүүхдийн товлолын дархлаажуулалтын хугацааг хойшлуулан дараагийн сард нөхөн дархлаажуулна.

3.7. Тусгаарлах байранд, гэрийн тусгаарлалтаас гарсны дараа 1 хүртэлх насны хүүхдийн гэрийн эргэлтийг өрх, сум, тосгоны эмч, сувилагч Эрүүл мэндийн сайдын батлагдсан журмын дагуу хийнэ.

3.8. Жирэмсэн эмэгтэй, хүүхэд гэрийн ажиглалтад байгаа үед ямар нэг зовиур илрэх, зөвлөгөө авах шаардлагатай бол харьяалах өрх, сум, тосгоны эмч болон 119, 100, 103, 80086829 утсанд, гадаадын иргэн бол Интермед эмнэлгийн- 80105577, SOS Medical эмнэлгийн- 91913122 утсанд хандана.

3.9. Тусlamж үзүүлж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн халдвартын сэргийлэлт, хяналтын дэглэмийг баримталж, хувийн хамгаалах хувцас хэрэгслийг батлагдсан зааврын дагуу хэрэглэнэ.

Дөрөв. Эх барихын тусlamж, үйлчилгээ

4.1. Хэрэв тусгаарлалтын хугацаанд жирэмсэн эмэгтэйд зовиур илэрч хэвтүүлэн эмчлэх шаардлагатай бол орон нутагт Нэгдсэн эмнэлгийн Халдвартын тасагт, нийслэлд Халдварт өвчин судлалын үндэсний төвд /ХӨСҮТ/-д хэвтүүлэн эмчилнэ.

4.2. Жирэмсэн эмэгтэйг тусгаарлан ажиглах хугацаа дууссан, шинжилгээгээр коронавирус илрээгүй, халдвартын шинж тэмдэггүй бол эх барихын тусlamж, үйлчилгээг харьяаллын амаржих газар, орон нутагт нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг, сумын эрүүл мэндийн төвд үзүүлнэ.

4.3. Хэвтүүлэн эмчлэх, төрүүлэх, мэс ажилбар хийх тохиолдолд батлагдсан заавар журам стандартыг мөрдөнө.

4.4. Төрөх өрөөнд нярайд нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусlamжийг зохих зааврын дагуу үзүүлнэ. Эхийн биеийн байдал хөнгөн үед нярайг эхээс тусгаарлахгүй ба эхийн сүүгээр хооллоно. Эхийн биеийн байдал хүнд үед эхэд амьсгалын замын эмгэгийн ямар нэгэн шинж тэмдэг илэрч байгаа үед хооллолтын бусад аргыг сонгож, эхийн саасан сүүгээр хооллоно.

4.5. Коронавирусын халдварт (COVID-19) батлагдсан эсвэл сэжигтэй гэж үзвэл эх, нярайг 14 хоног тусгаарлана.

Тав. Мэдээлэл

5.1. Жирэмсэн эмэгтэй, хүүхдийн биеийн байдал, жирэмсний явц, тэдэнд үзүүлсэн эмнэлгийн тусlamж, үйлчилгээний талаарх мэдээллийг 24 цагийн дотор Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусlamжийн газарт мэдээлнэ.

5.2. Эрүүл мэндийн хөгжлийн төв мэдээллийг нэгтгэн, дүгнэж, сар бурийн мэдээлэлд мэдээлнэ.